

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРААС
2019 ОНЫ НАЙМДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2019.07.26 - 2019.08.25/

2019 оны 08 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт	Хариуцах албан хаагч	Хувь
1	2	3	4	5	6	7
1	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан тус газартай холбоотой арга хэмжээний биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Биелэлтийг үнэн зөв, бодитой гаргаж хүргүүлсэн байна.	“Чингис хаан” олон улсын нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийг Хөшгийн хөндий дэх шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгээс ирүүлсэн “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-нд тусгах саналгүй талаар Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх захиргааны албаны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зохицуулагч инженер Н.Сүнжидмаад цахимаар хүргүүлсэн болно.	Хяналтын улсын байцаагч	100
2		Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд албан хаагчдаас авч, нэгтгэн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.08.26-ны өдрүүдэд хүргүүлсэн.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч	100

1	2	3	4	5	6	7
3	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2018 онтой харьцуулан гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	ГИХГ-аас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2019 оны 8 дугаар сарын статистик тоог гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.08.26-ны өдөр хүргүүлэв. Мэдээгээр 2019.07.26–2019.08.25-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 10 үүнээс хариутай албан бичиг 4, явсан бичиг 10, ирсэн өргөдөл 0, гомдол 1 байгаа бол 2018.12.11-2019.08.25-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 129 үүнээс хариутай албан бичиг 66, явсан бичиг 91, ирсэн өргөдөл 3, гомдол 1 байна. Харин 2017.12.11 - 2018.08.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 103 үүнээс хариутай албан бичиг 43, явсан бичиг 86, ирсэн өргөдөл 7, гомдол 0 байна	Хяналтын улсын байцаагч	100
4		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Албан даалгаврын биелэлтийг үнэн зөв гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 01, 03, 04, 05, 06, 07, 2018 оны 02, 04, 06, 08, 09, 10, 2019 оны 02, 03 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргаж 2019.08.27-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.	Хяналтын улсын байцаагч	100
5	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад бичиг баримтын хуурмаглал илрүүлэх төхөөрөмж ашигласан талаар тайлан гаргаж хүргүүлэх.	Тайланг үнэн зөв, өгсөн зөвлөмжийн дагуу гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад бичиг баримтын хуурмаглал илрүүлэх төхөөрөмж ашигласан талаарх тайланг гаргаж 2019.08.23-ны өдөр цахимаар хүргүүлэв.	Хяналтын улсын байцаагч	100

1	2	3	4	5	6	7
				Нийт 14 орны 19 гадаадын иргэний паспортыг тус төхөөрөмжийг ашиглан шалгасан байна.		
6	Виз, бүртгэлийн чиглэлээр	Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	Нийт 99 орны 1796 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 10, нэг удаагийн орох 1597, хоёр удаагийн орох 18, олон удаагийн орох 22, нэг удаагийн гарах-орох 33, олон удаагийн гарах-орох 6, нэг удаагийн дамжин өнгөрөх 110, түр ирэгчийн бүртгэл 281, хасалт 298, оршин суух зөвшөөрлийн хасалт 44 байна. Үүнээс гадна тус газрын албан хаагчийн алдаатай бичсэн визийн хуудас 3 ширхэгийг хүчингүй болгож, Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон визийг шинээр 13 орны 27 гадаадын иргэнд олгосон ба оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон виз 3 орны 6 гадаадын иргэн байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100
7	Виз, бүртгэлийн чиглэлээр	Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	Монгол Улсад орох визгүй нийт 4 орны 17 гадаадын иргэн, 1 харьяалагүй иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан ба гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 5 орны 15 гадаадын иргэнийг хилээр гаргаагүй болно. Шүүх, ШШГЕГ, прокурорын байгууллагын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100

1	2	3	4	5	6	7
8	Хяналт шалгалтын чиглэлээр	Барилга, зам гүүр үйлдвэрлэлийн барилга байгууламж, уул уурхай болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх.	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг тус газрын даргад танилцуулсан байна.	Тус газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 10/10 дугаар удирдамжийн дагуу Төв аймгийн Баянчандмань суманд үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй 1 орны 34 гадаадын иргэнийг шалгасан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар Хяналт шалгалтын газрын даргад танилцуулан, энэ оны 8 дугаар сарын 19-ний өдөр 10/03 дугаартай албан шаардлагыг дээрх аж ахуйн нэгжид хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар	100
9		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 104 гадаадын иргэнд 8,650,000 төгрөг, 8 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 8/ 6,060,000 төгрөг, нийт 14,710,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгсөн.		100
10	Хяналт шалгалтын чиглэлээр	Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Тус газраас албадан гаргах дүгнэлтийг 1 орны 1 гадаадын иргэнд бичиж, төвд хүргүүлснээр “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 37 дугаар зүйлд заасны дагуу ГИХГ-ын даргын А/280 дугаар тушаалаар 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр албадан гаргасан бөгөөд төвөөс 3	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100

1	2	3	4	5	6	7
				орны 5 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.		
11		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 8 орны 79 гадаадын иргэн, 1 харьяалалгүй иргэн, нийт 80 иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 4 орны 65 гадаадын иргэнийг угтан авч буй уригч 14 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар	100
12	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах.	Төрийн үйлчилгээний албан хаагчдын хийсэн ажлыг нэгтгэн гаргаж ур чадварын нэмэгдэл олгуулах саналыг газрын даргад танилцуулж тушаал гаргасан байна.	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу төрийн үйлчилгээний 5 албан хаагчид тус газрын даргын 2019.08.23-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар ур чадварын нэмэгдэл олгосон.	Хяналтын улсын байцаагч	100

1	2	3	4	5	6	7
13		Гамшгийн эрсдлийн үед архивыг авран хамгаалах талаар сургалт зохион байгуулах.	Сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан байна.	Нийслэлийн Онцгой байдлын газрын Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр сургалт зохион байгуулж тус төвийн сургагч багш х/ч М.Цогтбаяр, а/д Д.Солонго нар 10 албан хаагчдад мэдээлэл хүргэж, дадлага сургуулилт хийлгэв. Сургалтаар албан хаагчид гамшгийн төрөл, гамшигт өртсөн хүнд анхны тусламж хэрхэн үзүүлэх талаар сурч мэдлээ.	Хяналтын улсын байцаагч	100
14		Төрийн албаны зөвлөлийн цахим санд албан хаагчдын мэдээллийг шивж оруулан баяжилт хийх.	Тус газрын албан хаагчдын 2019 оны 7 дугаар сарын нэмэгдлийг оруулсан байна.	Төрийн албаны зөвлөлийн цахим санд тус газрын албан хаагчдын мэдээлэл болох 2019 оны 7 дугаар сард авсан нэмэгдлийн /зэрэг дэв, төрийн алба хаасан хугацаа, ур чадвар, унаа, хоол/ талаарх мэдээллийг оруулан баяжилт хийлээ.	Хяналтын улсын байцаагч	100
15	Санхүү, хангалт, үйлчилгээний чиглэлээр	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.	Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.	Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 402,069,700 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 219,823,388 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 24,360,704 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 11,935,253 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.	Ахлах нягтлан бодогч	100

1	2	3	4	5	6	7
16		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.	НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2019.08.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 402,069,700 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 255,406,337 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2019.08.05-ны өдрийн дотор НДХ - т хүргүүлэн өссөн дүнгээр 53,126,032 төгрөгөөр тооцоо нийлэв.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
17		Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.	Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.	Албан хаагчдад шийтгэлийн хуудас 98, визийн хуудас 1500 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
18	Санхүү, хангалт, үйлчилгээний чиглэлээр	Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Бараа материалд 7,917,280 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
19		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 1,477,871 төгрөг, байрны түрээс 21,600,250 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн болно.	Ахлах нягтлан бодогч	100

1	2	3	4	5	6	7
20		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх.	Хүү торгууль өссөн дүнгээр 73,330,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 404,238,410 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч	100
21		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 10,905,700 төгрөгийн зарцуулалт гаргаж тайлагнасан.	Нярав	100
22		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын нийт 26 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1, сургалтын чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.	Нярав	100
23		Нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.	ХУД-ийн НДХ, Татварын хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газар нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын хэлтэст хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100

1	2	3	4	5	6	7
24	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, ААН, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Тус газарт ирсэн гомдлыг /иргэнээс ирсэн 1/ цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг гомдолд “Бүртгэл-хяналтын карт” хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилласан. Тус газарт энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл байхгүй ба мэдээг 2019.08.26-ны өдөр Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийг хэлтэст тус тус хүргүүлсэн.	Хяналтын улсын байцаагч	100
25	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн 10 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, хариутай 4 албан бичигт “Бүртгэл-хяналтын карт” хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллав. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар “Бүртгэл-хяналтын карт”-д тэмдэглэсэн ба 10 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.	Хяналтын улсын байцаагч	100
26		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газрын даргын баталсан 2 тушаал, ирсэн 10, явсан 10 албан бичиг, төлөвлөгөө, биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлэв.	Хяналтын улсын байцаагч	100

1	2	3	4	5	6	7
27		Хэвлэмэл хуудасны зарцуулалтын бүртгэлийг хөтлөн тус газрын даргад танилцуулах.	Засгын газрын 2001 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилт хангагдсан байна.	Агаарын замын боомт хариуцсан газрын өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайланг гаргаж тус газрын даргад танилцуулж ажиллалаа. Албан бичгийн А4, А5, тодорхойлолтын А5 хэвлэмэл хуудас, тус газрын даргын тушаалын хэвлэмэл хуудасны 2019 оны 7 дугаар сарын 1-ээс 31-ний өдрийн зарцуулалтын тайланг 2019.08.01-ний өдөр гаргаж тус газрын даргад танилцуулж ажиллалаа.	Хяналтын улсын байцаагч	100
28		Архивын өрөөний чийг, дулааныг хэмжиж бүртгэл хөтлөх.	Хэмжилтийг өдөр бүр хийж, бүртгэл хөтөлсөн байна.	Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг 2019.07.26-2019.08.25-ны өдрүүдэд өдөр бүр хэмжиж дэвтэрт бичилт хийн ажиллав. Дулаан 23-25С, чийгшил 50-60RH байна.	Хяналтын улсын байцаагч	100
29	Олон нийттэй харилцах чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл,	Ахлах нягтлан бодогч	100

1	2	3	4	5	6	7
				Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл.		
30		Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Цахим хуудсанд тус газраас 2019 оны 7 дугаар сард хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл, гомдол, зохион байгуулсан сургалт, 8 дугаар сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангав.	Хяналтын улсын байцаагч	100

Төлөвлөсөн: 30
Биелсэн: 30
Хагас биелсэн: 0
Биелээгүй: 0
Хувь: 100